АРХАНГАЙ АЙМГААР АЯЛСАН ДОТООДЫН АЯЛАГЧДЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА



АГУУЛГА



- Судалгааны арга зүй, аргачлал
- Судалгаанд оролцогчдын мэдээлэл
- Аялагчдын зан төлөв
- Аялагчдын сэтгэл ханамж
- Дүгнэлт

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ

Түүврийн хэмжээ

384 ДОТООДЫН ЖУУЛЧИН
(Сүүлийн 3 жилийн хугацаанд Архангай аймгаар аялсан дотоодын жуулчид)

Судалгааны зорилго

Архангай аймагт сүүлийн 3 жилийн хугацаанд аялсан аялагчдын аяллын хэв маяг, зан төлөв болон аяллын үед авсан үйлчилгээний талаарх сэтгэл ханамжийн үр дүнг тодорхойлох

Судалгааны зорилт

- Архангай аймагт аялсан аялагчдын зан төлөвийг тодорхойлох

  Аялсан маршрут, аялалд зарцуулсан хугацаа, хэдэн сард, хэнтэй аялсан, аялсан тээврийн хэрэгсэл, хоноглосон сууцны төрөл, аяллын үед орон нутгийн иргэдээс авсан үйлчилгээ, аялалд зарцуулсан дундаж зардал, аяллын зардлын задаргаа, тухайн маршрутыг сонгож аялахад нөлөөлсөн хүчин зүйлс

- Архангай аймаг дахь аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх сэтгэл ханамжийн түвшинг тодорхойлох

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ

Зураг 1. Сүүлийн 3 жилийн хугацаанд Архангай аймгийн сумдаар аялсан байдал, хувиар



Судалгааны түүврийн хэмжээ

Судалгааны мэдээллийг асуумжийн аргыг ашиглан утсаар болон талбар дээрээс мэдээллийг цуглуулсан.

Архангай аймагт Ковид-19 цар тахлын өмнөх үе болох 2019 оны байдлаар гадаадын 21,822 жуулчин, дотоодын 76,708 жуулчин аялсан байна.

Түүврийн хэмжээг тогтоохдоо дотоодын 76,708 жуулчныг эх олонлог болгон авсан ба түүврийн хэмжээг тогтоохдоо эх олонлогоос 95 хувийн итгэх түвшинтэй, ±5 хувийн алдааны хязгаартайгаар тооцоход түүврийн хэмжээ **384** байна. Энэ нь эх олонлогийг хангалттай төлөөлж чадах түүвэр юм.

Аялагчдын хувьд сүүлийн 3 жилийн хугацаанд Архангай аймагт аялахдаа Тариат, Ихтамир, Эрдэнэбулган, Өгийнуур, Цэнхэр, Чулуут сумаар голлон аялжээ.

СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН МЭДЭЭЛЭЛ

График 1. Судалгааны оролцогчдын мэдээлэл



Судалгаанд оролцогчдын 34.4% эрэгтэй, 65.6% эмэгтэй байна. Насны бүтцийн хувьд үндэсний хүн амын насны бүтэцтэй ойролцоо байна.

Өрхийн сарын дундаж орлого улсын хэмжээнд 1,621,454 төгрөг байгаа бол, хотод 1,700,382, хөдөөд 1,471,851 төгрөг байна (УСХ, 2021).

Харин судалгаанд оролцогчдын өрхийн сарын дундаж орлого хөдөөгийн дунджаас 50.5% доогуур орлоготой бол, 49.5% дээгүүр орлоготой байна. Мөн орлогын бүлгээр авч үзвэл 8.3% нь 600,000 төгрөг хүртэл орлоготой байна.

График 2. Аялал жуулчлалын талаар мэдээлэл авч буй эх сурвалж



АЯЛАГЧДЫН ЗАН ТӨЛӨВ

График 3. Архангай чиглэлд хэнтэй хамт аялсан бэ?

Аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгчдийн хувьд гэр бүл болон найз нөхдийн хамт аялж байгаа аялагч нарт зориулсан аяллын бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгох нь илүү тохиромжтой байна.

7.8

Архангай чиглэлд аялахдаа нийтдээ аялсан өдөр

4.9

Үүнээс Архангай аймагт аялсан өдөр

1,156,289

Нэг аялагчийн аялалд зарцуулсан зардал

АЯЛАГЧДЫН ЗАН ТӨЛӨВ

Зураг 2. Архангай чиглэлд аялсан өдрийн тоо болон үүнээс Архангай аймагт өнгөрүүлсэн өдрийн тоо



Хүснэгт 1. Аялалд зарцуулсан зардлын дундаж хэмжээ, мөг

Батцэнгэл	**2,003,333**
Хотонт	1,792,549
Цэнхэр	1,468,190
Хангай	1,452,500
Тариат	1,374,062
Жаргалант	1,369,047
Хашаат	1,333,939
Эрдэнэмандал	1,298,529
Төвшрүүлэх	1,295,357
Өндөр-Улаан	1,287,500
Цахир	1,240,517
Эрдэнэбулган	1,237,440
Чулуут	1,217,938
Их-Тамир	1,217,569
Өгийнуур	1,117,350
Хайрхан	1,117,241
Цэцэрлэг	1,100,000
Өлзийт	1,002,380
Булган	900,000

АЯЛАГЧДЫН ЗАН ТӨЛӨВ

График 4. Аялалд зарцуулсан зардлын дундаж хэмжээ

- Тээвэр, хоол, уух зүйлсийн зардал хамгийн их жин дарж байна.
- Аялагчдын ихэнх нь майхантай аялагчид байгаа тул байрших хэрэгсэлд бага зардал зарцуулжээ.
- Зардлын *9.7%-г нутгийн иргэдээс бараа, бүтээгдэхүүн худалдан авахад, 5.8% нь үзвэр, үйлчилгээний зардалд* зарцуулсан байна.

АЯЛАГЧДЫН ЗАН ТӨЛӨВ

Хүснэгт 2. Аялахдаа ашигласан хэрэгсэл, үйлчилгээний мэдээлэл, хувиар

Аялахдаа ашигласан тээврийн хэрэгсэл	Аялахдаа ашигласан, буусан байршуулах хэрэгсэл	Аялахдаа нутгийн иргэдээс авсан үйлчилгээ
• Хувийн машин-90.9% • Автобус-7.6% • Хөлсний тэрэг-2.6% • Онгоц • Нисдэг тэрэг • Дугуй • Бусад-1.6%	• Жуулчны бааз/резорт-13.5% • Гэр кэмп-40.4% • Зочид буудал-6.3% • Малчин айл өрх-18.2% • Хувийн майхан-60.2% • Бусад-3.9%	• Хөтөч хөлслөх-2.3% • Машин хөлслөх-1.8% • Нутгийн иргэдээс бэлэг дурсгал, бүтээгдэхүүн худалдан авах-52.1% • Завь хөлслөх-16.9% • Морь унах-39.1% • Хоол захиалах-40.6% • Гэр байранд хонох-43.5% • Бусад-8.3%

- Архангай чиглэлд аялж байгаа аялагчдын ***98.7% нь 6-8 сарын хооронд аялж*** байна. Үүнээс ***хавар, намар, өвлийн аялал хөгжөөгүй*** байгааг харж болно.
- 3 хүн тутмын 1 нь 7 сард аялж байгаа тул ***оргил ачааллын үеэр аялал жуулчлалын зохицуулалт шаардлагатай*** байна.
- Монголчууд аялах чиглэл, маршрутаа өөрсдөө хайж, судлах замаар аялах нь их бөгөөд 2020 оны хавар МУИС -ийн Аялал жуулчлалын факультетын профессоруудын хийсэн асуулга судалгааны "Та аялахдаа аялал жуулчлалын компани ашигладаг уу?" гэсэн асуултад 95% нь "үгүй" гэж хариулжээ.
- Дотоодын аялагчид ихэвчлэн машинаар аялж, хоол хүнсээ ч машиндаа ачиж авч явах нь их тул ресторан, цайны газар зэрэг үйлчилгээний байгууллагыг бараг ашигладаггүй байна. Энэ нь дотоодын аялал жуулчлалын хэрэглээний хэмжээ бага байгаагийн нэг шалтгаан гэж үзэж байна (ЖАЙКА, 2021).

АЯЛАГЧДЫН ЗАН ТӨЛӨВ

График 5. Аялахдаа тухайн орон нутгийн ямар хүчин зүйлсийг чухалчилдаг эсэх

- Архангай аймгаар аялахдаа байгалийн тогтоц, үзэсгэлэнт газар, түүхэн дурсгалт газрыг чухалчлан сонгон аялж байна.
- Мөн цэвэр агаар салхинд гарч амрах сонирхолтой аялагчид цөөнгүй байна.

АЯЛАГЧДЫН ЗАН ТӨЛӨВ

Хүснэгт 3. Архангай аймгаар аялна гэхээр таны санаанд шууд бууж буй зүйлс

Уул, Нурууд	Байгаль, цаг уур	Амьтан, ургамал
Суварга хайрхан Булган уул Хоргын тогоо Тайхар чулуу	Байгалийн өвөрмөц тогтоц бүхий, үзэсгэлэнтэй сайхан байгальтай	Загасчлал Сарлаг Тарвага Жимс, жимсгэнэ Адуу, мал
Бүтээгдэхүүн, Үйлчилгээ	**Гол, мөрөн**	**Эртний түүхэн дурсгал**
Цагаан идээ	Өгийнуур Рашаан ус (Цэнхэр) Тамирын гол Чулуутын гол Шивэртийн халуун рашаан Тамирын гол Үзэсгэлэнтэй гол, нуурууд	Хөшөө дурсгалууд Сүм хийдийн туурь Түүхэн соёлын үнэт өв, дурсгалууд

- Архангай аймагт аялна гэхээр аялагчдын санаанд шууд бууж буй зүйлсийг тодруулахад Тэрхийн цагаан нуур, Хоргын тогоо, Чулуутын гол, Өгийнуур гэх мэт одоогийн ***аялал жуулчлалын голлох бүтээгдэхүүн, үйлчилгээ, байршлуудыг*** нэрлэж байна.

АЯЛАГЧДЫН СЭТГЭЛ ХАНАМЖ

- Аялагчдын *90 орчим хувь нь Архангай аймгаар аялсандаа эерэг сэтгэгдэлтэй* байгаа бөгөөд бусад хүмүүст санал болгоно гэжээ.

График 6. Архангай аймагт дахин аялах эсэх

АЯЛАГЧДЫН СЭТГЭЛ ХАНАМЖ

- Аялагчдаас Архангай аймгийн аялал жуулчлалын үзмэрүүд болох дараах зүйлсийг үнэлүүлэхэд дунджаар 4.3 оноо буюу маш сайн сэтгэл ханамжтай гэсэн үнэлгээг өгсөн.
- Аялагчдын хувьд Архангай аймгийн аялалд нөлөөлөх бүхий л үзүүлэлтүүд таалагдсан байна.
- Харин олон төрлийн сонирхолтой соёлын ажиллагаануудтай гэсэн үзүүлэлт бусад үзүүлэлтээс бага зэрэг доогуур үнэлгээтэй байна.

График 7. Архангай аймгийн аялал жуулчлалын үзмэрүүдийн талаар өөрийн сэтгэгдлийн үнэлгээ

АЯЛАГЧДЫН СЭТГЭЛ ХАНАМЖ

- Аялагчдаар Архангай аймгийн аялал жуулчлалын үзвэр, үйлчилгээнүүдийг үнэлүүлэхэд дунджаар 3.8 оноотой буюу сэтгэл ханамжтай гэсэн үнэлгээг өгчээ.
- Харин хүрээлэн буй орчны даац хэтэрсэн, чимээ шуугиан ихтэй гэсэн хоёр үзүүлэлт дээр сэтгэл ханамж дунд байна. Үүнийг цаашдын үйл ажиллагаандаа анхаарах шаардлагатай.
- Дэлхийн эдийн засгийн форумын тайланд дурдсанаар аливаа улс орны аялал жуулчлалын салбарын орлого байгаль орчны төлөв байдалтай нь шууд хамааралтай байдаг байна. Аялал жуулчлалыг хөгжүүлэхдээ зохих хяналтыг тавиагүйгээс үүдэн жуулчдыг татах гол бүтээгдэхүүн болох байгаль орчин доройтоход хүрдэг аж. Үүнээс улбаалж зорин ирэх жуулчдын тоо багасаж, нутгийн иргэдийн амьжиргааны түвшин буурах нөхцөл байдал үүснэ (форум, 2017).

График 8. Аялсан газрын үзвэр, үйлчилгээний талаарх сэтгэгдлийн үнэлгээ

АЯЛАГЧДЫН СЭТГЭЛ ХАНАМЖ

Архангай аймгаар аялсан аялагчдын сэтгэл ханамжийн түвшнийг тодорхойлоход дунджаар 3.7 буюу сэтгэл ханамжтай гэсэн үнэлгээг өгсөн. Энэ үнэлгээ нь харьцангуй санаа зовох зүйл бага буюу боломжийн гэсэн үзүүлэлт юм. Харин жуулчны байршуулах газрын амрах, тоглох спортын үйл ажиллагаа, нөхцөл, ариун цэврийн байгууламжийн хүртээмж, тав тух гэсэн үзүүлэлтэд сэтгэл ханамж дунд зэрэг ба цаашид энэ үзүүлэлтийг сайжруулж сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

График 9. Аялсан газрын үзвэр, үйлчилгээний талаарх сэтгэгдлийн үнэлгээ

ДҮГНЭЛТ

Архангай аймагт аялж байгаа дотоодын аялагчдын хувьд хоорондоо ялгарах хэв шинж бага байна.

- Өөрөөр хэлбэл аялагчдын хооронд нийгэм, хүн ам зүйн үзүүлэлт, аяллын бүтээгдэхүүн, үйлчилгээнээс хамаарсан ялгарал бий болоогүй байна. Аялагчид (67.4%) гэр бүлтэйгээ, дунджаар 7.8 өдөр (үүнээс Архангай аймагт 4.9 өдөр), 1,156,289 төгрөгийг зарцуулж, ихэвчлэн хувийн машинаар, майханд хоноглон Архангай аймгаар аялж байна. Аялалд зарцуулсан зардлыг төрлөөр авч үзвэл нийт зардлын 60 гаруй хувийг тээврийн зардал, хоол, уух зүйлст зарцуулжээ. Нийт зардлын 40 орчим хувийг тухайн орон нутагт үлдээж байна.

Аялал жуулчлалын оргил ачааллын үед аялал жуулчлалд зориулсан суурь дэд бүтцүүд болох жуулчны бааз, зорилтот байршлуудын ачаалал даах боломж хязгаарлагдмал байна.

- Архангай чиглэлд аялагчдын 98.7% нь 6-8 сарын хоорон аялж байна. Энэ нь даацыг хэтрүүлж, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх шалтгаан болж байна. Үүн дээр зохицуулалт хийж, аялал жуулчлалын нөөцийг хамгаалах шаардлагатай.

Аялагчдад зориулсан аяллын тусгайлсан бүтээгдэхүүн, үйлчилгээ төдийлөн хөгжөөгүй байна

- Архангай аймгийг сонгон аялж буй гол шалтгаан нь байгалийн тогтоц, үзэсгэлэн болон түүхэн дурсгалт газруудыг үзэх ажээ. Харин зорилтот буюу тусгайлсан аялал жуулчлалыг сонгон аялсан жуулчин бараг байхгүй байна.

Архангай аймгаар аялсан аялагчид аялалдаа эерэг сэтгэгдэлтэй, сэтгэл ханамжтай байна

- Аялагчид аялал жуулчлалын үзмэрүүд, үзвэр, үйлчилгээг эергээр үнэлж, сэтгэл ханамж сайн байгаа ч хүрээлэн буй орчны даац хэтэрсэн байдал, чимээ шуугиан, жуулчны байршуулах газрын амрах, тоглох, спортын үйл ажиллагаа, ариун цэврийн байгууламжийн хүртээмж, тав тухад сэтгэл ханамж дунд зэрэг байна. Эдгээр үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай.

Эндээс дүгнэвэл ойрын **ирээдүйд Архангай аймаг дотоодын аялагчдын аяллын гол бүс нутаг хэвээр** байхаар байна.

(976)-70137012

contact@mirim.mn

Монгол улс, Улаанбаатар 14181,
Сүхбаатар дүүрэг, 11-р хороо,
ПроВан барилга, 15 давхар,
1502 тоот

Холч Голч Бүтээлч...

www.mirim.mn